



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвжавын САЙНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2026. 07. 02 № УИХ-03/2145
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



П.САЙНЗОРИГ

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

000000189

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА

Э.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

000000189

Д.БУМ-ОЧИР
Ш.БЯМБАСҮРЭН



С.БЯМБАЦОГТ


Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР



Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ



М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ

000000189

С.ЗУЛПХАР
Ц.ИДЭРБАТ
Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ


Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ







000000189

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА



Д.ПҮРЭВДАВАА



Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА



Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ


Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН



ДАВ.ЦОГТБААТАР

ДАМ.ЦОГТБААТАР



000000189

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН

000000189



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвжавын САЙНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2026. 06. 30 № ЧИХ-03/7961
танай _____-ны № _____-г

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт~~388~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



П.САЙНЗОРИГ

000000187



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.САЙНЗОРИГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.04.28 № ХЭТ/1399

танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт ⁰³ ... хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265005661

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“3.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригоос санаачлан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригоос санаачлан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд үзэл баримтлалыг зарчмын хувьд дэмжиж, дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.7 дахь заалтад тусгасан “дотоодын бараа”-ны тодорхойлолтод тухайн барааны нийт өртгийн тодорхой хувь нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нэмүү өртөг бий болгох үйл ажиллагааны үр дүнд бүтээгдсэн байх шалгуурыг нарийвчлан тусгах;

2.Хуулийн төслийн 1.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт түншлэл, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүргийн хувийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгахаар заасан боловч тодорхой хувь заагаагүй тул гэрээний үүргийн 100 хүртэл хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх нөхцөл бүрдэж байна.

Иймд түншлэл, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүргийн хувь хэмжээ, түүний дээд хязгаарыг тодорхой хуульчилж, захиалагч тухайн хязгаар дотор тендер шалгаруулалтын баримт бичигт гүйцэтгэх үүргийн хэмжээг чөлөөтэй тогтоохоор тусгах;

3.Хуулийн төслийн 1.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой, давуу эрх олгох барааны нэр, төрлийн жагсаалтыг Засгийн газар батлахаар тусгасан нь шинэ тутам зах зээлд нэвтэрч байгаа бизнесийн өрсөлдөөнийг хязгаарлаж болзошгүй байх тул жагсаалтад суурилсан, зөвшөөрлийн шинжтэй механизмаас татгалзаж, бүртгэлийн шинжтэй, нээлттэй зохицуулалт болгон өөрчлөх;

4.Хуулийн төслийн 1.8 дугаар зүйлийн 4.5 дахь заалтад ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг 34 хүртэлх насны залуучууд эзэлдэг, 25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгжид давуу эрх олгохоор тусгасан нь хүнийг насаар ялгаварлаж, өрсөлдөөнийг хязгаарласан шинжтэй байх тул уг заалтыг хасах;

5.Хуулийн төслийн 1.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох

болон байгальд ээлтэй технологи, арга хэмжээг нэвтрүүлсэн” гэсэн нөхцөлийг нэмэх;

6.Хуулийн төслийн 1.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт хиймэл оюунд суурилсан цахим систем нь тендерт оролцогчдын үйл ажиллагааны чиглэл, чадавх, өмнө хийж гүйцэтгэсэн ажил зэрэгт үндэслэн тухайн оролцогчид оролцох боломжтой тендерийн талаар мэдээлэл өгдөг байх зохицуулалтыг нэмж тусгах;

7.Хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлд заасан тендер шалгаруулалт зохион байгуулах харилцаанд бараа, ажил, үйлчилгээг багцлахад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, орон нутгийн үйлдвэрлэгчдийн тендерт оролцох боломжийг хязгаарлахгүй байх зарчмыг тодорхой тусгах.

Тухайлбал, багцын тоо, нэр, төрөл, үнийн дүн, ижил төстэй байдлаар нэгтгэх асуудлыг захиалагч дур мэдэн шийдэх боломжгүй, өрсөлдөөнийг бодитоор дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн оролцоог хангахуйц тодорхой шалгуур, үндэслэлтэйгээр багцлах зохицуулалтыг оруулах;

8.Нээлттэй тендер шалгаруулалтыг удаа дараа зохион байгуулсан боловч шаардлага хангасан оролцогч гараагүй тохиолдолд худалдан авах ажиллагаа амжилтгүй болох нөхцөл байдал үүсдэг тул хуулийн төслийн 4.3 дугаар зүйлд “Нээлттэй тендер шалгаруулалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулахад шаардлага хангасан оролцогч гараагүй тохиолдолд захиалагч тендер шалгаруулалтыг цахим системд үнийн санал дуудах аргаар зохион байгуулж болно” гэсэн зохицуулалтыг нэмэх;

9.Хуулийн төслийн 4.6 дугаар зүйлд заасны дагуу гэрээ шууд байгуулах аргаар зарласан тендер шалгаруулалтын хувьд оролцогч нь ерөнхий шаардлагыг бүрэн хангасан байх ёстой. Харин төрийн нууцад хамааруулсан тендер шалгаруулалтад оролцогч нь ерөнхий шаардлага хангахгүй бол гэрээ шууд байгуулах нөхцөл үүсэхгүйгээс гадна тухайн тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хуулийн төслийн 7.4 дүгээр зүйлд заасны дагуу маргаан хянан шийдвэрлэх зөвлөл хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй байгааг анхаарах;

10.Хуулийн төслийн 5.2 дугаар зүйлийн 1.3 дахь заалтад “ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өөрчлөгдсөн бол захиалагч магадлалын дүгнэлтэд үндэслэн тухайн ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг өөрчлөх” гэж заасныг хасах.

Энэ заалтын хүрээнд төсөвт өртгийг нэмэгдүүлсэн тохиолдолд өмнөх гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах нь цаашид төслийн хугацааг санаатайгаар удаашруулах, нэмэлт зардал бий болох зэрэг төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг бууруулах сөрөг үр дагаврыг бий болгож, төсөвт дарамт үүсгэх эрсдэлтэй байна;

11.Хуулийн төслийн 6.6 дугаар зүйлд тусгасан худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт бараа, ажил, үйлчилгээний жишиг техникийн тодорхойлолтыг салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны дүгнэлт, зөвлөмжийг харгалзан боловсруулах, сургалт, судалгаатай холбоотой зарим чиг үүргийг мэргэжлийн нэгдсэн холбоо, иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх талаар тодорхой тусгах. Түүнчлэн, хуулийн төслийн 2.4 дүгээр зүйлд заасан шалгалт, туршилтыг салбарын мэргэжлийн нэгдсэн холбоотой хамтран гүйцэтгүүлэх гэсэн агуулгыг оруулах;

12.Хуулийн төслийн 7.2 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Тендер шалгаруулалтын маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой журмыг батлан гаргахаар заасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.2.4 дэх заалтад “гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүрэгтэй холбоотой асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй” гэж заасантай нийцэхгүй байх тул хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл боломжийг арилгах зорилгоор холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгах;

13.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “34.7.Тендер шалгаруулалтын маргааны хянан шийдвэрлэх зөвлөлд гаргаагүй нотлох баримтыг шүүхэд гаргахгүй” гэсэн нь захиргааны хэргийн шүүх шийдвэрээ зөвхөн талуудын тодорхойлсон нөхцөл байдал, нотлох баримтын хүрээнд бус, хэргийн бодит байдлыг тогтоох зорилгоор нотлох баримтыг өөрөө цуглуулж, талуудын тэгш байдлыг хангахад чиглэсэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн мөн чанар, зарчимд нийцэх эсэхийг нягтлах;

14.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “4.1.17.““зөвлөх үйлчилгээ” гэж төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах,...” гэсний дараа “угсралт, суурилуулалт” гэж нэмэх;

15.Хуулийн төслийн зүйл, хэсгийн дугаарлалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт заасантай нийцүүлэх, түүнчлэн, хуулийн төслийн зарим зүйл, заалтын эшлэл буруу байгааг анхаарах шаардлагатай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР